

ЯРУУ НАЙРАГЧ ДАНЗАНГИЙН НЯМСҮРЭНГИЙН УРАН БҮТЭЭЛ ДЭХ
ОРОН ЗАЙ, ЦАГ ХУГАЦААНЫ ДҮРСЛЭЛИЙГ АЖИГЛАВАЛ...

Б.Пүрэв-Очир, Л.Цэрэнчимэд¹

Өдөр болгон би
Өвсөн дээр гишгэнэ билээ
Өнө хожмоо тэд

Над дээр ургана билээ! хэмээн шүлэглэсэн “Эрэнцавын эвдрээгүй Нямсүрэн”, “Өвсний шүлэгч”, “Ирж яваа цагийн яруу найрагч” зэрэг тодотголтой найрагч Данзангийн Нямсүрэнгийн уран бүтээлийг эмхтгэсэн цуврал гурван ботгийг 2010 онд хэвлүүлж нийтийн хүртээл болгожээ. Түүний уран бүтээлийг судалж, үнэ цэнг товойлгон гаргасан судлаачдын санал гайлбар цөөнгүй байдаг. Тухайлбал: Яруу найрагч доктор Г.Мэнд-Ооёо, доктор А.Мөнх-Оргил, доктор Н.Энхтөр, утга зохиол судлаач, яруу найрагч Г.Аюурзана, доктор П.Батхуяг нарыг дурдаж болно. Эдгээрээс Соёлын гавьяат зүтгэлтэн, яруу найрагч Гомбожавын Мэнд-Ооёо: “Д.Нямсүрэнгийн амьдралын өөр нэг орон зай бол хэн бүхэнд хараахан хүрч очоогүй байгаа үгийн ид шидийг бясалгахуйгаар нээдэг яруу найргийн шамбал юм. Хэний ч анзаарч хардаггүй харганын ёроолд хунгарласан хазаар өвс Д.Нямсүрэнгийн яруу найргийн шамбалд <<Алтан хазаар>> өвс болж гэрэлтэхийг XXI зууны уншигчдад нээх болно”² гэж угтан бэлгэдэж бичсэн билээ. Бас утга зохиолын доктор А.Мөнх-Оргилын бичсэн “Данзангийн Нямсүрэн буюу дөрвөн цаг” өгүүлэлд дурдсан цаг хугацааны мөчлөгийн тухайг эс тооцвол түүний уран бүтээл дэх орон зай, цаг хугацааны асуудал, эх бичвэр хоорондын хамаарлын асуудлыг төдийлөн хөндөж гаргаагүй ажээ. Найрагч Д.Нямсүрэн “*өвсөн дунд төрж – амьдарч – түүнд шингэж*” гоо сайхны дээд чанарт тэмүүлэнхэн явсныхаа хувьд уран бүтээлээ туурвихдаа, өөрийн сэтгэлийн байгальд ертөнц, бодит байдлыг **өвсөөр** дамжуулан, зурж, урлаж, буулгахдаа юун тухай хүүрнэж, хэрхэн ярууссаныг: “...*агь хүмэл өвс, алтан гөрөөс өвс, алтан хазаар өвс, алтан харгана өвс, борог өвс, бог өвс, бужгар өвс, ганга өвс, зөөлөн өвс, налсан өвс, ногоон өвс, норсон өвс, охид шиг өвс, өлийн өвс, өлөнжүүр өвс, оргөст өвс, сахлаг өвс, согтсон өвс, солгой өвс, сулихар өвс, суль өвс, сүмэн өвс, сүмбэ өвс, тарианы өвс, улаан намрын өвс, ухаа өвс, хаг өвс, хамхуул өвс, хиргүй өвс, хөх өвс, цантсан өвс, цоор өвс, шаргал өвс, шинэ өвс, чийгтэй өвс, эр өвс...*” зэрэг дүрслэл бүхий эгэл юмсын холбооноос үүдүүлэн харж болохоор байна. Энэ нь найрагчийн дотоод чинад дахь урансайхны хийсвэрлэл, түүний шүлгүүд буюу эх бичвэрийг “ойлгох”, “тайлах”, “үг ба утга руу нь нэвтрэх” асуудалтай нягт холбоотой юм. Дээр дурдсан хослолоор орон ба цаг буюу тодруулбал, дөрвөн цагийн эргэлт орчил хөдөлгөөний төлөөлөл хэрхэн илэрснийг доорх байдлаар нэгтгэж болох.

1. Монгол Улсын Боловсролын Их Сургууль

2. Мэнд-Ооёо, Г., Яруу найраг-Шидэт долгион I, Уб., 2007, 188-р тал

байдлын дүр загвар юм”⁶(З.Я.Тураева) гэх зэргээр уран сайхны эх бичвэр дэх орон зайн тухай ойлголтыг тэмдэглэсэн байх бөгөөд үүнийг цаг хугацаанаас ангид авч үзэх боломжгүй юм. Эдгээр үзэл баримтлалыг эш үндэс болговол, эх бичвэрийн найруулгад дүрслэгдэж буй юм, үзэгдлүүдийн орон, цаг, байдал шинж, үнэлэмжийн утгыг ертөнц, хүний амьдрал дахь бодит зүйлийн тусгал, тэдгээрийн үлгэр загвар, үгээр зурсан зураг бөгөөд илрэх хэлбэрийн хувьд янз бүр байна гэж хэлж болох юм.

4. “Аливаа текстийн утга агуулга болоод урансайхны туурвилзүйн хэлбэр нь тухайн улс үндэстний өвөрмөц онцлог, зан заншил, нийгэм түүхийн уг сурвалж, ёсзүй, ёс суртахуун, ергөнцийг үзэх үзэл, соёл оюун санааны амьдралын бүхий л хүрээг хамарч, өөр өөр төрөлд янз бүрийн түвшинд өвөрмөц дүр төрхтэй илэрдэг универсаль шинжтэй ойлголт... Үгийн урлаг нь (урансайхны текстүүд)хүний оршихуйн тухай бичвэрүүдээс өөр юу ч биш. Энэ утгаараа яруу найраг, уран зохиолыг өнөөдөр ертөнцийн хийгээд хүний амьдралын мөн чанарыг хамгийн оновчтойгоор дүрслэн харуулах бололцооны дээд түвшин гэж үздэг болсон...”⁷ (С.Энхбаяр)
Д.Нямсүрэнгийн “Гурван сарын наймны шүлэг”, “Өвснөөс сонссон үлгэр”, “Дөрвөн цаг”, “Чиний үлээх лимбэ, миний үлээх өвс”, “Он он жилийн дараа”, “Цас орохын өмнө”, “Гурван цаг”, “Нэгэн намрын бүсгүй” бүлэг шүлэг, “Цаглашгүй”, “Явлаа”, “Буурчийн суурин”, “Цаг болж нөхцөл бүрдэхэд”, “Үүлнээ өөрийгөө харахуй”, “Өвснөө өөрийгөө үзэхүй”, “Дугариг дугариг дүрсүүдэд”, “Үүрийн өмнөхөн”, “Зүүрмэг үдшийн аялгуу”, “Өөрийн минь шүлэг”, “Сэтгэл зүрх эргэхгүй” . “Үүл нүүхэд”, “Солгой өвс”, “Хавриас хаварт”, “Марал буга ирсэн шөнө”, “Цав цагаан эгшин”, “Үзэсгэлэнт хасарваана мод дэлгэрээд”, “Өдөр болгон би”, “Зангуу”, “Бүдэг бадаг сар” гэх зэрэг өвс ба хүн байгалийн харьцааг дүрслэн хүүрнэсэн тавь гаруй шүлгээс үзэхэд, цаг хугацаа, орон зайн хамаарал, мэдрэмжийн сонгодог жишээ болсон:

Өдөр болгон би

Өвсөн дээр гийшгэнэ билээ.

Өнө хожмоо тэд

Над дээр ургана билээ(***) гэх юмуу эсвэл,

Үүл нүүхэд

Би нүүнэ.

Өвс халиурахад

Мөн халиурна.

Өдөр өдрийн наран тэрэг

Над дээгүүр өнгөрнө.(***) гэх мэт мөртийг бэлхнээ харж болно. Энд *одор*

болгон- давтамжит мөчлөг цаг, үүл нүүх-өвс халиурах-наран тэрэг өнгөрөх цаг хугацааны эргэж буцахгүй шугаман урсгал. *өвсөн дээр*- бодит нээлттэй орон. *өнө хожим*- ирээдүй цаг. *над дээр ургах-над дээгүүр өнгөрөх* орны харьцаа гэсэн байдалтай одоо ба ирээдүй цагийн хэлхээгээр *дээр-доор* гэсэн орон зайн харьцааг дүрсэлжээ. Орон ба цагийн энэхүү харьцаа нь “би” хэмээх үйлдэгчээр нөхцөлдөж холбогдсон байна. Тэгвэл, дараах шүлгээс орон зайн хийгээд цаг хугацааны эсрэгцэл илэрсэн дүрслэлийг харж болно. Жишээ нь:

...Эртний Хүннүгийн хиргисүүр чулуун дээр ч бичигдээгүй шүлгийг

Эрэнцавын хөх хяруутай өвсний үзүүрээр цасан дээр зохиож,

Эдэлбэр тариалан орны шүлэгч Дү-Фүгийн Тянь Шань уулнаас өндөрг

Энэ монголын хамгийн нам дор Хөх нуурын хөвөөнд мандуулав, би... (“Явлаа”) хэмээсэн эхний хоёр мөр нь *өнгөрсөн ба одоо*, гурав, дөрөвдүгээр мөр нь *өндөр ба нам дор* гэсэн орон цагийн эсрэг харьцаанд суурилж, “шүлэг найргаа туурвих” гэсэн санаагаар холбогдсон байх

6. Тураева, З.Я., Лингвистика текста, М., 1986, стр. 20

7. Энхбаяр, С., Утга зохиолын онол, Уб., 2011, 296-р тал

Б.Пүрэв-Очир, Л.Цэрэнчимэд

ажээ. Ер нь урансайхны эх бичвэр дэх бодит, нээлттэй орон зайн босоо чигт харьцангуй туйлыг олонхи зохиолчид газар-тэнгэр, хөхрөгч-хөрст гэх мэтээр дүрслэх нь элбэг байдаг. тэгвэл найрагчийн хэд хэдэн шүлэгт эрхэс тэнгэр, эх газар гэсэн орон зайг **үүл-өвс** гэсэн байдлаар эсрэгцүүлж төлөөлүүлсэн нь тийм ч түгээмэл байдаггүй дүрслэл болсон байдгийг доорх жишээнээс харж болно.

<p>Бүрий барайд Гэрийн минь ойр Гөрөөс ирдэг гэж Бодном... ...Язганасан будаа шиг Хүүхдийг минь үзэж Ялгуун сайхан толгойгоо Өвснөөс цухуйлгадаг байх Бүүр энүүхэнд Лааны гэрэл мэт байсан Нөгөө гөрөөс Бүдэг бадаг сар болоод Үүлний цаагуур орчихвол Яанаа, хөөрхий... ("Бүдэг бадаг сар")</p>	<p>Хонгорзул гэж--- Тэнгэрлэг биеийг Тэнгэр бурхан заяасан Үхэх төрөхийн хоорондох Үзэсгэлэн--- Үүл, өвс хоёрын Дундах тэнгэр Үйлийн үртэй Хүний сэтгэлийг Өдөр нь эсгэж Шөнө нь оёсон Үйлийн хайч шиг Бүсгүй!!! ("Хонгорзул")</p>	<p>...Үнэн ба худал аль нь шөнийн цэцгийг ялгах адил хэцүү. Үүл, өвс хоёрын хооронд үнэр сайтын хаанаас анхилах нь зүг үгүй Үйтэн хуарын хээ тэмтрэгдэм зүсний сайхныг сонсвоос Үзэм болоод чавганы исмэл уухын зуур согтохын зэргэмж нэгэн...("Нарангэрэл")</p>
---	--	---

Энэ мэт бодит орон зай, цаг хугацааны харилцан хамаарал бүхий сонин дүрслэл байхаас гадна харьцангуй хийсвэр орныг дүрсэлсэн нь цөөн бус байна. Жишээ нь:

Хоөрхөн цэцгэнд нь од хоноод,
Хөх одонд нь би хоноод,
Тэгээд **өвс өвснийг** ая аяхан чагнавал
Тэндэх **өвснүүд** аяар аяархан жимбүүрдэв ээ?

Болохгүй дээ гэж бодсон ч

Бор хул ганц **сулийг нь** тасадмаар санагдаад.

Түүний хөндийгөөр үлээн үлээмээр.

•Түүнийг уйлуулан өөрөө инээмээр.

Найман зовхис уясан ойртож ирээд,
Ямархан нэг лимбэ эгшиглэх мэт
Ямархан нэг лимбэ эгшиглэн байна гэж
Найман зовхисоос нэг болжмор нисэн ирээд.

Ертөнцийг дэндүү сайхан шүү гэх миний **өвсний**

Есөн нүхний нэгийг таглаад буучихваа! ("Чиний үлээх лимбэ, миний үлээх өвс") гэсэн шүлгийн эхний бадагт нээлттэй боловч бодитой хүртэгдэх орон бус, хийсвэрлэх сэтгэлгээний үр дүнд илрэн гарсан харьцангуй хийсвэр орон зайг дүрслэн үзүүлээд, бадаг хоорондын холбоосжилт нь **өвсөөр** илэрсэн байгаа нь давтагдашгүй өвөрмөц болжээ. Цаашилбал, найрагчийн бүтээлд хийсвэр орон зайг дүрслэн үзүүлсэн сонирхолтой баримтууд байна. Жишээ нь:

Дугариг дугариг дүрсүүдэл

Би оршном бөлгөө,
Өвлийн пасны гэрэлд
Дэнгийн сүүдэр тийм бүлгээ

Өөрийн минь шүлэг
Дугуй цагаан манан болоод
Өвснүүд чиний эзгүйгээр төөрөөд

Хав нохой мэт ээ... (“Өөрийн минь шүлэг”) энэ шүлэгт “*дугариг дүрсэнд би орших - шүлэг дугуй цагаан манан болох*” гэж хийсвэр орон зайг дүрсэлсэн нь цагийн дарааллаар нөхцөлдсөнийг харж болно. Тэгвэл дараах шүлэгт:

...Цав цагаан **цасны** доорх **өвс ногоо**-цагийн үргэлжлэл
Цав цагаан **цас** миний хөлийн гишгэх эгшгийг **өвсөнд** аваачна.
Өвсний дээгүүр үүр цайхад өглөөгүүр түүнийг цуглуулбал
Үнэр нь хагд болоод хадны шорооны үнэртэй...
Цав цагаан нойронд би дарагдаад.

Цав цагаан биед уусан **өвс ногооны** зүгт очно... (“Цав цагаан эгшин”) **цас –өвс** цагийн үргэлжлэл гэсэн нь мөчлөг цаг(өвөл-зун)-ийн илрэл, мөн өвлөөс хаварт, хавраас зун гэх байдлаар гасралтгүй урсах цагийн эргэлтэд хүний амьдрал үргэлжилнэ, эцэст нь мөнхийн нойрт дарагдсанаар, бодит оршихуйгаас ангижирч, бодит бус оюун санааны ертөнцөд шилжинэ гэсэн санаа илрэн гарчээ. Түүнчлэн найрагчийн бүтээл дэх өвөрмөц гэж болохуйц орон зайн нэг дүрслэл бол “өвс хийгээд түүний эргэн тойрон дахь харьцангуй хийсвэр орон” байгааг өмнө цухас дурдсан билээ. Үүний илэрхийлэл болсон нэгээхэн дүрслэлийг дараах баримт тодорхой харуулж байна. Жишээ нь:

Өвснөө өөрийгөө үзэхүй
Өчигдөр биш өнөөдөр хугарсан
Өннийн хөх өвс
Өөрөө би мөөн.

Өтлөхүйн цаг дор шүлэг минь
Хувилгаан чанарт шилжиж,
Өнгө өнгийн цэцэгс болж дэлгэрээд
Өвсний шүүдрээр хөл нүцгэн явах бүсгүйн

Өлмийд үнэрээ халгалах болно...(“Өвснөө өөрийгөө үзэхүй”) гэсэн шүлгийн эхний бадагт шууд утгаар бус байгаль дэлхий нь цаг цагийн урсгал, түүний орчилд буй хүмүүн гэдэг бол “*өнгөрсөнд торжс – өнөөдрөөр түүчээлэн - маргааныг угтдаг*” хэмээсэн гурван цагийн хэлхээ юм гэдгийг үзүүлсэн нэг санаа, цаашлаад “*өнө – өтлөхүй*” хоёрын зуурт бүтээсэн бүхэн үр дүн, ач тусаа өгөх нь өвсний шүүдэр мэт эмзэг бөгөөд маш нарийн орон зайд ялдам тансаг үнэрээ халгалан үлдэх өвстэй адил юм гэх байдлаар өвөрмөц нарийн уялдаатай орон-цагийн хамаарлаар бүтсэн дүрслэл болсон нь сонирхолтой байна.

Найрагчийн бүтээлээр илрэн гарч буй орон ба цагийн өөр нэг онцлог бол **бүсгүй хүний** гоо сайхныг магтан дуулсан санаагаар нь холбоосжуулсан дүрслэл юм. Тухайлбал:

Он он жилийн дараа
Одод хэвээрээ гялалзана.
Он он жилийн хойно
Харин би байхгүй байна

Чиний нулимсыг алган дээрээ дусааж
Чийгтэй гараар хацрыг чинь энхрийлж
Яаж шүү таануусыг хайрлалаа даа!

Хонгор охид минь

Яг л тэр байдлаараа
Он он жилийн дараа
Өвсний үзүүрт шүүдэр болж

Өлмийг чинь угааж аргадыя. Би! (“Он он жилийн дараа”) цаг хугацаа урсан өнгөрөхөд эрхэс ертөнц хэвээр байх агаад, би хэмээх нэгэн бодгаль үгүй болсон ч, хонгор та нараа

хайрласан сэтгэл минь хэвээрээ “**өвсний үзүүр**”-т шүүдэр болж, аргадна гэсэн нь угтаа орон зайн хэлбэрийн хувьд **бодитоос бодит бус руу**, харьцааны талаас **дээрээс- доош**, байдал шинжийн хувьд **буйг аас- үгүйд** шилжих ч сэтгэл гэдэг үргэлж мөнхийн юм гэсэн, магадгүй найрагчийн сэтгэлийн тэрхүү сайхан байгалийн илэрхийлэл ч байж болох дүрслэл байна. Дараах шүлэгт өгүүлсэн нь:

Судалт ногоолин оюу чимэг зүрхний баясал
Сулинхээрийн задгай хатирааны үүлэн явдал
Сулихар өвс усанд ургасан үзэсгэлэнт тэнгэр
Сул чулуунд гэрэлтэх эрдэнийн очир алмааз

Өндөр газрын бүсгүй сэргэлэн бөгөөд сэрүүн
Өвснөөс шувуу нисэх нь цэнхэр цэнхэр аялгуу
Үс зүсний нийлэмж нартай борооны солонго

Өндөр газрын бүсгүй үзэх нүдний баясгалан... (“Нэгэн намрын бүсгүй-2”) суль өвс гэдэг ус биш элсэнд ургадаг маш тэжээллэг ургамал, хэрэв зээ энэ өвс удвал цэцэг шиг усанд ургадаг байсан бол үзэсгэлэнтэй сайхан байх буй гэсэн санаагаар өвөрмөц үнэлэмж бүхий оруулбар хийсэн орон зайн дүрслэл болжээ.

...Олон олон цантай морьд уяанд шилгээн зогсдог байсан урьдын үдэш
Одод цавцайтал инээх жийхгар үнэгэн нүдэт намрын хүүхнүүд
Орон гаран **сүмбэ шаргал өвсний дотор** гадна биеэ үзэхүй

Огторгуй даяарын цас гялбам нэгэн царай сайт байжухуй... (“Нэгэн намрын бүсгүй-5”) энэ шүлэгт бүсгүй хүний сайхныг дүрсэлсэн нь илэрхий бөгөөд мөн л өвснөө холбогдсон “**шаргал өвсний дотор- гадна биеийг үзэх**” гэсэн харьцангуй хийсвэр орон илэрсэн нь сонин юм. Энэ мэтээр найрагчийн уран бүтээлд **өвс-цаснаа** холбогдсон бодитой болон хийсвэр орон зай - цаг хугацааны харилцан хамаарал бүхий өвөрмөц дүрслэл байхаас гадна, өвсөөр төлөөлүүлсэн төлөөлөл бүхий дүрслэл ч цөөнгүй байна. Өвс болон цас нь бодит юмын нэрлэлт боловч хам сэдэв, эх бичвэрийн найруулгад мөчлөг цаг, орон зайн харьцаа, орон ба цагийн хамаарлыг нарийн уялдуулан гаргаж болдог чухал хэрэглүүр болох нь ажиглалтаас харагдаж байна. Энэ бүхэн угтаа,

<p>...Толгодын орой зэрэглээтэй сайхан Торгон салхи сэвэлзэх сайхан • Хөх ногооны униар татах сайхан Хөх мананд нь ороолгон суух сайхан...</p>	<p>...Гэгээн борооны усыг тосох сайхан Гээг үсээ хүүхнүүд угаах сайхан Агь хүмлийн үнэр сэнгэнэх нь сайхан Аясхан бодол хол ойрыг санах сайхан...</p>
<p>... Дэлхийн чулуунд хяруу цавцайх сайхан Дэрсээр дээр нь шүлэг бичих сайхан Дэвэр дэвэх салхинд сэтгэл гэгэлзэх нь сайхан Дэндуу ойрын хайраас холд байх нь сайхан...</p>	<p>...Өглөө босоход цас орсон байх нь сайхан Өрхний оосор даялахад тооноор цас унах сайхан Гадаа уул толгод гялбалзах нь сайхан Ганц нэг өвс салхинд сэвгэнэх нь сайхан...</p>

хэмээсэн энгийн бөгөөд ер бусын тансаг дүрслэлтэй, гэгээн сайхны илэрхийлэл болсон эргэх дөрвөн цагийн орчил дахь хүний амьдрал ба ертөнцийн байдлыг өгүүлсэн дүр зураг гэж үзэх үндэстэй юм.

ДҮГНЭЛТ

1. Найрагч Д.Нямсүрэнгийн уран бүтээл дэх орны ба цагийн ай, түүний илэрсэн хэлбэр, онцлог нь “өвс ба байгаль, өвс ба хүн”, тэдгээрийн сайхантай салшгүй холбоотой илрэн гарсан байх нь баримтаас харагдаж байна.

2. Дээрх өгүүлэгдэж буй юмс (өвс, цас, гоо үзэсгэлэн)-ыг үндэс болгож, эх бичвэрийн гол агуулга санаагаа илэрхийлснийг хувь найрагчийн ертөнцийг үзэх үзэл, уран бүтээлээ туурвидаг арга барил, бичлэгийн ур маягаас ангид авч үзэх боломжгүй юм. Энэ нь найрагч нэгэнтээ “... би өвсийг бөөгийн дуудлага шиг дуудаж шүлгээ бичдэг” .“би шүлгээ өвс, бүсгүй хүнгүйгээр тосоолдоггүй” хэмээн өгүүлснээс илэрхий ажээ.

3. Зохиолч өөрөө энэ мөрөөр орон зайг, энэ үгээр цаг хугацааг, энэ бадгаар орон хийгээд цагийн харилцан хамаарлыг үзүүлж байна гэж шүлгийн агшиндаа ухамсарлаагүй байлаа ч, түүний шүлгүүд дэх цаг хугацаа-орон зайн дүрслэл нь дөрөвхөн мөр шүлгийн мөр мөрөөр солбицсон, эсвэл нэг мөрөнд буй өгүүлбэрийн аль нэг үгээр илэрсэн нь сонирхолтой бөгөөд чухамдаа энэ л зүй тогтол нь эхийн хэл шинжлэлийн зангилаа асуудал, бусад шинжлэх ухааны холбоо уулзвар зааг дахь чухал сэдэв. Нөгөөтэйгүүр, зохиолчийн бодит байдлыг хийсвэрлэх чанар, тухайн зүйлийг өөрийнхөөрөө таньж, харж түүнийг бичвэрт буулгасан дүр зураг юм.

4. Яагаад, “өвс-цас”, “өвс-бороо”, “өвс-бүсгүй”, “өвс- хайр сэтгэл”, “өвс-шувуу”...! вэ? Үүнийг *өвс адил норж, ноцож, согтож* бүтээлээ туурвисан хувь найрагчийн метафор сэтгэлгээ, уран бүтээл хоорондын холбоо (межтекста, intertext)-ны асуудал буюу шүлгээс шүлэгт, бичвэрээс бичвэр хооронд буй учирзүй хийгээд шалтгааны хамаарлыг танихуйн үүднээс, ойлгохуйн үүднээс гүнзгийрүүлэн тайлбарлах асуудал мөн. Ингээд эргэцүүлэхүй дор дорнын уудам талаас төрж, “шаргал галынхаа бүх өвсөөр чөдөр зангидаж үзсэн” тэр их авьяас билэгт найрагчийн дотоод чинадын тиг нь ёстой л нөгөө <<Амитаба шиг...>>-ээ үлэмж энгүүн бөгөөд уран, бас нууцлаг бөгөөд танигдашгүй аж. Түүнийг нь мөн л ирж яваа цаг цагийн судлаачид, шинжээчид л өвс өвсөнд нь бөхийн, цэцэг цэцэгсийн шүүдэр буюу намарга гүүж цуглуулахтай адил машид хичээнгүйлэн ажиглаж оролдож гэмээнэ нээж чадах байх. Чингэвээс “Нямсүрэн судлал”-ын далайд дусал нэмэр болно. Бид монгол хэл-уран зохиолын багш-найрагч Д.Нямсүрэнгийн хэд хэдэн “өвс”-ний үндсэнд нэгхэн дусал ус сүрчив. Ургаж соёлоход нь нэмэр болог!

Б.Пүрэв-Очир, Л.Цэрэнчимэд

АШИГЛАСАН НОМ

1. Аюурзана, Г., Монголын топ яруу найрагчид, Хөх толбо сонин, Уб., 2012, №26, нүүр 4
2. Базаррагчаа, М., Монгол хэлний өгүүлбэр судлал, Уб., 2005
3. Баг-Ирээдүй, Ж., Түвшинтөгс, Б., Монгол хэл шинжлэлийн өгүүлэлзүй, Уб., 2012
4. Галбаатар, Д., Уран зохиол нэвтэрхий толь, Уб., 2012
5. Гальперин, И.Р., Текст как объект лингвистического исследования, М., 2007
6. Монголын зохиолчдын эвлэл, Цогдоржийн Бавуудорж туурвилзүй, шүүмж судлал, Уб., 2010
7. МУБИС, МоСС, Монгол судлалын чуулган, э/ш-ний бичиг, № 45, Уб., 2011
8. Мэнд-Ооёо, Г., Яруу найраг- шидэт долгион I, Уб., 2007
9. Николина, Н.А., Филологический анализ текста, М., 2003
10. Папина, А.Ф., Текст: его единицы и глобальные категории, М., 2002
11. Пүрэв-Очир, Б., Монгол хэлний эхийн өгүүлбэрзүй, 4 дүгээр дэвтэр, Уб., 2004
12. Соёл яруу найргийн академи, Монголын зохиолчдын эвлэл, "Данзангийн Нямсүрэнгийн сэтгэлийн байгалийг нээхүй" э/ш-ний бага хурлын эмхтгэл, Уб., 2007
13. Сэтгэлийн байгаль буюу Данзангийн Нямсүрэн, эмхтгэсэн Л.Бор, Г.Хандмаа, Уб., 2006
14. Тураева, З.Я., Лингвистика текста, М., 1986
15. Цэрэнчимэд, Л., Урансайхны эхийн найруулгад илэрсэн харшууллын онцлог, хэрэглээ, Уб., 2010
16. Энхбаяр, С., Утга зохиолын онол, Уб., 2011
17. Энхтөр, Э., Д.Нямсүрэнгийн яруу сайхны сэтгэлгээ, Уб., 2004

ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

1. Ирж буй цаг, тэргүүн боть Уб., 2010, ("Эрхлэн нийтлүүлэгчийн учирлал" ерөнхий цэц Г.Мэнд-Ооёо)
2. Амиитаба, дэд боть, Уб., 2010, (Ерөнхий цэц Г.Мэнд-Ооёо)
3. Сарны цагаан үүлс, гутгаар боть, Уб., 2010 ("Сарны цагаан үүлс"-ийн тодотгол ерөнхий цэц Г.Мэнд-Ооёо)

ABSTRACT

It is observed that spatial and time descriptions by the poet can be explained in relation to "grass and nature or grass and human being". Why is there "grass and snow", "grass and rain", "grass and woman", "grass and love" or "grass and bird"? The poet's striking use of metaphor and intertext should be carefully explained by cognitive and comprehensible forms. Although the poet did not intend to portray space in a particular line or time in particular phrases or spatial and time interconnections in a verse, interestingly, spatial and time descriptions in his poems are revealed in the following ways: time and spatial description lines are intersected in a verse of poems or time and spatial description is described in one of the words in a sentence line.

We have watered roots of some "grass" by D.Nyamsuren, the poet and teacher of Mongolian language and literature. Hope it will help it grow bigger!